



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2023/83/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2023 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор Л.Соёлмөнх Утас: 7033-3019 Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс:976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2023.03.15 № 120

танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН
ДАРГА А.АРИУНТУЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Архангай аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг Нийгмийн даатгалын ерөнхий газраас 86.7 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8,177,443.2	9,654,125.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,066,661.0	7,735,570.6
33	АВЛАГА	2,108,295.1	1,916,690.2
35	БАРАА МАТЕРИАЛ	2,487.1	1,864.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	758,247.6	797,631.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	758,247.6	797,631.4
39200	Биет хөрөнгө	743,067.6	782,451.4
39300	Биет бус хөрөнгө	15,180.0	15,180
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,935,690.8	10,451,757.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	218,946.4	145,240.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	218,946.4	145,240.8
41300	Өглөг	23,973.4	1,095.2
41400	Урьдчилж орсон орлого	194,973.0	144,145.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,716,744.4	10,306,516.4
51	Засгийн газрын хувь оролцоо	8,716,744.4	10,306,516.4
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	224,570.9	224,570.9
51200	Хуримтлагдсан үр дүн	8,491,559.4	10,081,331.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	614.2	614.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,935,690.8	10,451,757.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ Мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	76,988,634.5	106,126,378.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	28,787,246.8	26,558,477.3
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	28,787,246.8	26,558,477.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,546,061.5	719,183.4
120	Нийтлэг татварын бус орлого	1,546,061.5	719,183.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	46,655,326.2	78,848,717.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	77,914,949.4	104,535,134.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	77,914,949.4	104,535,134.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	724,222.5	697,845.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	504,329.0	525,129.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,625.1	65,684.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,322.3	25,463.7
2104	Хангамж, бараа материалын зардал	24,688.8	16,903.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,500.0	3,155.4
2107	Томилолт, зочны зардал	3,749.4	2,976.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,171.6	17,223.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,836.2	41,309.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,190,726.9	103,837,289.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(926,314.9)	1,591,243.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(926,314.9)	1,591,243.9

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	77,179,882.7	106,250,573.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	28,229,812.2	26,551,189.7
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	28,229,812.2	26,551,189.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	589,948.6	602,700.6
120	Нийтлэг татварын бус орлого	589,948.6	602,700.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	48,360,121.8	79,096,682.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	77,914,440.3	104,581,663.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	77,914,440.3	104,581,663.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	678,795.0	671,972.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	504,329.0	525,129.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,625.1	65,684.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,322.3	25,463.7
2104	Хангамж, бараа материалын зардал	24,182.8	16,903.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,500.0	19,155.4
2107	Томилолт, зочны зардал	3,749.4	2,976.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,086.3	14,776.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000.0	1,883.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,235,645.2	103,909,691
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(734,557.6)	1,668,909.6
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(734,557.6)	1,668,909.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,801,218.6	6,066,661
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,066,661.0	7,735,570.6

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,643,837.2	9,643,837.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(777.8)	(777.8)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,643,059.4	9,643,059.4
9	Тайлант үеийн үр дүн	(926,314.9)	(926,314.9)
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,716,744.4	8,716,744.4
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,716,744.4	8,716,744.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,472)	(1,472)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,715,272.5	8,715,272.5
19	Тайлант үеийн үр дүн	1,591,243.9	1,591,243.9
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	10,306,516.4	10,306,516.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ Мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	95,548,374.60	94,764,003.10	784,371.50	99.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	95,548,374.60	94,764,003.10	784,371.50	99.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	670,851.90	655,972.40	14,879.50	97.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	532,553.80	525,129.20	7,424.6	98.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,941.20	65,684.40	1,256.8	98.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,782.30	25,463.70	2,318.6	91.65
2104	Хангамж, бараа материалын зардал	18,100.00	16,903.20	1,196.8	93.39
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,155.40	3,155.40	-	100
2107	Томилолт, зочны зардал	3,273.20	2,976.40	296.8	90.93
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,146.00	14,776.50	2,369.5	86.18
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,900.00	1,883.60	16.4	99.14
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	94,877,522.70	94,108,030.70	769,492.0	99.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	94,877,522.70	94,108,030.70	769,492.0	99.19
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	95,548,374.60	32,045,718.10	63,502,656.5	33.54
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	9,414,697.50	9,414,697.50	-	100
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	86,133,677.10	22,029,513.70	64,104,163.4	25.58
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		601,506.90	(601,506.90)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		6,066,661.00	(6,066,661.00)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		7,735,570.60	(7,735,570.60)	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	44	44	0	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ Мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	16,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,000.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй.

Залруулагдаагүй нийт 6,185.9 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрснээс, 1,122.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 5,063.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Цалингийн давтан тооцооллоор нэр бүхий ажилтнуудад 1,122.4 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1. Албан хаагчдад 3 сарын цалин дээр 5063.5 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг олгохдоо албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлэх, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын дагуу үнэлэн дүгнэж, зохих хувиар тооцоогүй нийтэд нь ижил мөнгөн дүнгээр олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 2.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно, Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолын хавсралт "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлэх, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 30 нэр төрлийн 37,311.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг мөрдөж холбогдох арга хэмжээг авч ажиллах

5.3.2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайланд 224570.8 мянган төгрөгийн дүрмийн сан тусгагдсан байхад улсын бүртгэлийн гэрчилгээнд 90484.1 мянган төгрөгийн дүрмийн сантай тусгагдаж 134086.7 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсан байна.

Энэ нь Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалаар баталсан "Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам"-ын 8.2.Хуулийн этгээдийн дараах мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг хуульд өөрөөр заагаагүй бол ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлд бүртгүүлнэ:8.2.3.хувь нийлүүлсэн хөрөнгө; гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалаар баталсан "Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам"-ыг мөрдөж, холбогдох арга хэмжээг авч ажиллах

5.3.3. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Нэмэлт санхүүжилтийн дансаар 16000.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэснийг санхүүгийн тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардлаар тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4-т үнэн зөв байх" гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нийгмийн даатгалын сан	5	6,185.9	1	1,122.4	1	5,063.5	3	0	0	0	0	0